

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр

Дугаар: 2016/03

Улаанбаатар хот

Огноо: 2016 оны 9 дүгээр сарын 09-ний өдөр

Цаг: 10:00-14:00

Байршил: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Бэст Вэстэрн Туушин зочид буудал, Сүлд хурлын танхим

Хурлын дарга: Ч.Ганхуяг

Хурлын нарийн бичгийн дарга: С.Халиунаа /хувьцаа эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хуулийн зөвлөх/

Хувьцаа эзэмшигч нарын тоо: 31

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 96, 327,508 ширхэг энгийн хувьцаа

Хурлын ирц бүрэн: 96,73%

Хуралд урилгаар оролцож буй хүмүүс:

1. Гүйцэтгэх захирал Ц.Батсайхан;
2. Төлөөлөн Удирдах Зөвлөл /цаашид "ТУЗ" гэх/-ийн дарга Д.Нарангэрэл;
3. ТУЗ-ийн гишүүн Д.Дэлгэрмаа;
4. ТУЗ-ийн гишүүн Ж.Оюунгэрэл;
5. ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Амарсанаа;
6. ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Ундарга;
7. Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох төлөөлөгчид;
8. Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК-ийн холбогдох төлөөлөгчид;
9. Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн төлөөлөгч.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ

1 дэх асуудал:

1. Компанийн дүрмийн өөрчлөлтийг Компанийн тухай хуулийн дагуу шинэчлэн батлах. (2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн ээлжит хурлаар оруулсан дүрмийн өөрчлөлтийг хүчингүй тооцсон асуудалтай танилцах.)
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн Л.Ундаргын томилгоог хүчингүйд тооцох,
3. ТУЗ-ийн нэг хараат бус гишүүнийг нөхөн сонгуульд нэр дэвшүүлэх, томилох;

4. 2016 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 2016/12 тоот Төлөөлөн Удирдах Зөвлөлийн “Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах” шийдвэр, тогтоолыг хүчингүйд тооцох, дээрх асуудлыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулах.
5. Бусад.

ХЭЛЭЛЦСЭН НЬ

Тооллогын комиссын дарга Б.Намуугэрэл: Монгол Шуудан ХК-ийн 2016 он 9 дүгээр сарын 9-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд нийт 99,586,363 ширхэг хувьцаа эзэмшигчдээс саналын эрхтэй 96,327,508 ширхэг хувьцаа эзэмшдэг 31 хувьцаа эзэмшигч хуралд биеэр ирсэн нь 96.73 хувь буюу Компанийн тухай хууль болон Монгол Шуудан ХК-ийн дүрмийн ирцийн шаардлагыг хангаж байх тул ирц бүрдсэнийг хуралд болон хурлын даргад мэдэгдэв.

Хурлын дарга Ч.Ганхуяг: 2016 оны 6 дугаар сарын 30-ны өдөр хувьцаа эзэмшигч Ард Санхүүгийн Нэгдэл ХК болон иргэн Х.Батхиниг нар нь Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал хуралдуулах санал, шаардлага гаргасан бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл нь хуульд заасан хугацаанд хурал зарлаагүй тул 2016 оны 7 дугаар сарын 22-ны өдөр дээрх хувьцаа эзэмшигчид нь ээлжит бус хурал хуралдуулах шийдвэрийг зарласан болно.

1 дэхь асуудал:

1. **ХЭЛЭЛЦСЭН НЬ:** Компанийн дүрмийн өөрчлөлтийг Компанийн тухай хуулийн дагуу шинэчлэн батлах. (2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн ээлжит хурлаар оруулсан дүрмийн өөрчлөлтийг хүчингүй тооцсон асуудалтай танилцах.)

Танилцуулгын гол агуулга: Хурлын дарга Ч.Ганхуяг: Дүрмийн төслийг бүхэлд нь зүйл заалт бүрээр танилцан батлах эсвэл жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан гол зохицуулалт болох 7.13, 7.14 дүгээр заалтыг хэлэлцэх эсэхээр талаар санал хэлэв.

Тусгай тэмдэглэл: Хувьцаа эзэмшигч Э.Алтаншагай: Монгол Шуудан ХК нь төрийн өмчийн оролцоотой компани учир, ТУЗ-д төрийн өндөр албан тушаалтныг томилход Авлигатай тэмцэх газраас хувийн ашиг сонирхлыг тодорхойлдог тодорхойлолт авч томилох үүрэгтэйг дурьдав.

ТУЗ-ийн гишүүн Д.Дэлгэрмаа: Дүрмийн төслийн 9.10.8-д “Салбар төлөөлөгчийн газрын удирдлагыг ТУЗ-тэй зөвшилцсөнөөр томилж, чөлөөлөх, тэдэнтэй компанийг төлөөлөн хөдөлмөрийн болон үр дүнгийн гэрээ байгуулах” гэж заасан нь 22 салбар, төлөөлөгчийн газрын дарга болгоныг томилох болгонд ТУЗ-өөр оруулах шаардлага гарч байна.

Компанийн засаглалын үндэсний зөвлөлийн дарга болон хувьцаа эзэмшигч Ганбаяр: Дүрмийн төслийн 8.12 дахь хэсэгт: “Хараат бус гишүүнд нийт саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдээс нэр дэвшүүлэхгүй” гэсэн дүрмийн зохицуулалт нь хувьцаа эзэмшигчийн эрх ашгийг зөрчсөн заалт байна.

ТУЗ-ийн гишүүн Д.Дэлгэрмаа: “дүрмийн нэмэлт өөрчлөлт оруулсан асуудал уу, шинэчилсэн найруулга оруулсан асуудал уу гэдгийг тодруулах шаардлагатай байна. Хэрвээ одоо байгаа саналын хуудсаар явуулбал “дүрмийн шинэчилсэн найруулга бус дүрмийн нэмэлт өөрчлөлт гэж томъёолох шаардлагатай.

Хариулт: Хувьцаа эзэмшигчийн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хуулийн зөвлөх С.Халиунаа: Хууль тогтоомжийн тухай хуульд заасан Дүрмийн төслийг дүгнэвэл “дүрмийн төслийн нийт агуулгын 50-аас дээш хувьд өөрчлөлт орсон бол дүрмийн

шинэчилсэн найруулга” гэж үзнэ, дүрмийн төслийн нийт агуулгын хувьд 50-аас доош хувьд өөрчлөлт орсон бол нэмэлт өөрчлөлт” орсон гэсэн зарчмыг баримталсан. Хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор Компанийн тухай хууль болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийг тавдугаар бүлгээр оруулсан бөгөөд бусад өөрчлөлтүүд нь үг үсгийн хувьд Төлөөлөн удирдах зөвлөл байсныг ТУЗ болгон өөрчилсөн өөрчлөлтүүд орсон бөгөөд агуулгын хувьд нэмэлт өөрчлөлт боловч нэр томъёолол дээр бүхэлд нь Төлөөлөн Удирдах Зөвлөл байсныг ТУЗ болгон, хувьцаа эзэмшигчдийн хурал байсныг ХЭХ болгон өөрчилсөн нь агуулгын бус хэл бичгийн шинэчилсэн найруулга болсон.

Түүнчлэн хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудалд “Компанийн дүрмийн өөрчлөлтийг Компанийн тухай хуулийн дагуу шинэчлэн батлах” хэмээн оруулсан болно.”

ТУЗ-ийн дарга Д.Нарангэрэл: 2016 оны 4 дүгээр сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “хэлэлцэх асуудалд ороогүй асуудал хэлэлцсэн” гэсэн үндэслэлээр дүрмийн төсөл хүчингүй болсон.

Нөгөөтэйгүүр Төрийн өмчийн хувьцаат компани байх үед батлагдсан дүрэм нь одоо хүртэл хүчин төгөлдөр байгаа бөгөөд хувьчлал явуулснаас хойш дүрмийг төслийг шинэчлэн батлаагүй нь компанийн нийт хувьцаа эзэмшигч нарын эрх ашгийг зөрчиж буй тул дүрмийн төслийг дэмжих саналтай байна. Гагцхүү Дүрмийн төслийн 7 дугаар хэсгийн 7.14, 8 дугаар хэсгийн 8.12 дугаар хэсэгт зөрүүтэй санал өгөх болоод байгаа тул хэлэлцэх асуудлын хүрээнд саналын хуудсыг загварт өөрчлөлт оруулах замаар санал хураалтыг явуулах асуудлыг хуралд оролцогсдоос асуух саналтай байна.

Дүрмийн төслийн 7.14-т хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудлыг 75-аас дээш хувийн саналаар хүчин төгөлдөр гэсэн нь хэт өндөр босго бөгөөд энэ асуудлыг Компанийн тухай хууль болон одоо байгаа дүрэмд заасан 50 хувийн хэмжээгээр батлах тул 7.14 болон 8.12-д тухайлан санал авах саналын хуудас боловсруулъя.

ТУЗ-ийн гишүүн Ж.Оюунгэрэл: 2016 оны ээлжит бус хурлаар оруулсан өмнө нь ТУЗ-өөр батлан оруулсан дүрмийн төслийг төрийн төлөөний хувьцаа эзэмшигч нь Болор сайдын удирдамж нэртэйгээр оруулж ирэн хувьцаа эзэмшигчдийн шийдвэр гаргасан ба уг дүрмийн төсөл нь хүчин төгөлдөр болоогүй. Хувьчлал явагдсанаас хойш одоо хүртэл Монгол Шуудан ХК-ийн дүрэм шинэчлэн батлагдаагүй нь жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг ихээр хөндөж байгаа.

Иймд нэгэнд ээлжит бус хурлаар оруулсан дүрмийн төсөл батлагдаагүй хойшлогдсон тул өнөөдрийн хурлаар аливаа нэгэн шийдвэрт хүрч, шинэчилсэн дүрмээ зайлшгүй батлах шаардлатай байна. Саналын хуудсыг төрийн хувьцаа эзэмшигч нарын саналын тусган санал хураалт явуулъя.

Хурал дарга Ч.Ганхуяг: Хувьцаа эзэмшигчдийн хурлын хурал хуралдуулах тогтоол болон зард хэлэлцэх асуудалд “Компанийн дүрмийн өөрчлөлтийг Компанийн тухай хуулийн дагуу шинэчлэн батлах” гэж заасан нь саналын хуудсанд “шинэчилсэн найруулгыг батлах” гэсэн томъёоллоор оруулах нь Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.10 “хувьцаа эзэмшигчдийн хурал нь хэлэлцэх асуудалд ороогүй асуудлыг хэлэлцэхгүй” гэсэн зүйл заалтыг зөрчихгүй гэж үзэн хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчид болон төрийн эрх бүхий төлөөлөгч, ажиглагч нараас эсрэг санал байхгүй тохиолдолд саналын хуудасны томъёоллыг өөрчилж 7.14, 8.14 дэхь хэсгийг хасан, 7.13 дээр хуучин дүрэм, компанийн тухай хуулийн дагуу 50 хувиар санал хүчин төгөлдөр болно гэсэн санал өгөх боломжоор хангаж дүрмийг батлуулах ажлыг шийдвэрлэх саналтай байна.

Хариулт: Хувьцаа эзэмшигчийн Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хуулийн зөвлөх С.Халиунаа: Хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдээс татгалзсан санал ирээгүй, мөн уг асуудал нь хувьцаа эзэмшигчдийн хэлэлцэх асуудалд хүрээнд тул саналын

хуудсанд дүрмийн төслийн 7.14, 8.12 дугаар хэсэг дээр тухайлан санал өгөх боломжоор хангаж саналын хуудсыг шинэчлэн тарая.

2. ДАРААХ ЗҮЙЛИЙГ БАТАЛСАН ТУХАЙ ШИЙДВЭР:

НЭГДҮГЭЭР АСУУДАЛ. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах.

1. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйл 62.1.1 дэх заалтыг үндэслэн “Монгол Шуудан” ХК-ийн дүрмийн шинэчилсэн найруулгыг хавсралтаар баталсугай.
2. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий тазрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлэхийг Гүйцэтгэх захиралд зөвшөөрсүгэй.
3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулж 2012 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн Төрийн өмчийн хорооны 300 тоот тогтоолыг хүчингүйд тооцсугай.

3. ЭНЭ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
99,586,363	100%	96,294,942	99.97%	99,586,363	100%	0	0.00%	99,586,363	100%	96,327,508	0.02%

1.1. Компанийн дүрмийн төслийн 7.14 дүгээр зүйлийг батлах тухай:

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
99,586,363	100%	30,567,650	31.73%	99,586,363	100%	65,727,293	68.23%	99,586,363	100%	19,998	0.02%

1.2. Компанийн дүрмийн төслийн 8.12 дугаар зүйлийг тухайлан батлах тухай:

Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
------------	------------	------------

Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
99,586,363	100%	30,576,316	31.74 %	99,586,363	100%	65,727,583	68.23%	99,586,363	100 %	11,042	0.01 %

2 дахь асуудал:

- 1. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Д.Ундаргаагын бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох тухай.

Танилцуулгын гол агуулга: Хурлын дарга Ч.Ганхуяг: Д.Ундаргын төрсөн ээж Оюун нь Монгол Шуудан ХК-ийн эрх бүхий албан тушаалтан буюу ТУЗ-ийн гишүүн байсан нь Л.Ундарга нь Компанийн тухай хуульд хараат бус гишүүнийг шаардлага хангахгүй байгаа юм. Иймд Д.Ундаргын томилгоог хүчингүй болгох асуудлыг уг хурлаар оруулсан тухай танилцуулав.

- 2. ДАРААХ ЗҮЙЛИЙГ БАТАЛСАН ТУХАЙ ШИЙДВЭР:**

ХОЁРДУГААР АСУУДАЛ. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Д.Ундаргааг томилсон томилгоог хүчингүй болгох тухай:

1. Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1.2 дахь заалт, Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 05 сарын 26-ны өдрийн 9/1828 тоот албан зөвлөмжийн 3.1 дэх хэсгийг үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Д.Ундаргаагын томилгоог хүчингүйд тооцсугай

3. ЭНЭ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН

Зөвшөөрсөн				Татгалзсан				Түдгэлзсэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
99,586,363	100 %	96,301,184	99.97 %	99,586,363	100 %	13,850	0.01 %	99,586,363	100 %	9,474	0.01 %

3 дахь асуудал:

- 1. ХЭЛЭЛЦСЭН НЬ:** Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нөхөн сонгуульд нэр дэвшүүлэх, сонгох тухай

Танилцуулгын гол агуулга: Хурлын дарга Ч.Ганхуяг: Компанийн тухай хуулийн дагуу 10 хувиас дээш хувьцаа эзэмшигч нараас нэр дэвшүүлсэн ТУЗ-ийн хараат бус гишүүнд нэр дэвшиж буй нэр дэвшигч нарыг танилцуулав.

Нэр дэвшигч Д.Анарын товч танилцуулга.

I. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Дэлгэр
2. Өөрийн нэр: Анар
3. Төрсөн Он, сар, өдөр: 1988.01.05
4. Төрсөн аймаг, хот: Улаанбаатар хот
5. Гэр бүлийн байдал /Зөвхөн ам бүлд байгаа хүмүүсийг бичнэ/

Таны юу	Овог нэр	Төрсөн он, сар, өдөр	Төрсөн аймаг, хот, сум	Одоо эрхэлж буй ажил	Утас
Эхнэр	Даваадорж овогтой Золзаяа	1988.04.15	Улаанбаатар хот	Хаан банк	99064467
Охин	Оюу-Номин	2010.12.06	Улаанбаатар хот		
Хүү	Оюу-Тулга	2015.05.03	Улаанбаатар хот		

II. БОЛОВСРОЛ /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Төгссөн сургууль	Хаана	Элсэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил, диплом, гэрчилгээний дугаар, эрдмийн зэрэг цол
6 дугаар дунд сургууль	Улаанбаатар хот	1995	2005	Бүрэн дунд
ШУТИС-КТМС	Улаанбаатар хот	2005	2009	Комьютерийн ухааны баклавар
Leverage сургалт			2011	Certificate
Positive mind сургалт			2015	JCI certificate
Project management			2015	PMI certificate

III. АЖИЛ ЭРХЛЭЛТ /Одоо хийж буй ажлаас эхлэн бичнэ/

Албан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
MONGOL ID GROUP	Төсөл хариуцсан захирал	2015 оноос хойш
MONGOL ID GROUP	Гүйцэтгэх захирал	2014-2015
SMART EVOLUTION	Ерөнхий захирал	2011-2014
UFC GROUP	IT менежер	2010-2011

Улаанбаатар Их Дэлгүүр	Худалдааны төлөөлөгч	2009-2010
------------------------	----------------------	-----------

Нэр дэвшигч Ч.Чинзоригийн товч танилцуулга

I. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1. Овог нэр: Чулуун
2. Өөрийн нэр: Чинзориг
3. Төрсөн Он, сар, өдөр: 1973.11.16
4. Төрсөн аймаг, хот: Улаанбаатар хот
5. Гэр бүлийн байдал /Зөвхөн ам бүлд байгаа хүмүүсийг бичнэ/

Таны юу	Овог нэр	Төрсөн он, сар, өдөр	Төрсөн аймаг, хот, сум	Одоо эрхэлж буй ажил	Утас
Эхнэр	Лхагваа овогтой Очирмаа	1987	Улаанбаатар хот	Хувиараа бизнес эрхлэгч	

II. БОЛОВСРОЛ /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

Төгссөн сургууль	Хаана	Элссэн огноо	Төгссөн огноо	Эзэмшсэн мэргэжил, диплом, гэрчилгээний дугаар, эрдмийн зэрэг цол
35 дугаар сургууль	Улаанбаатар хот	1981	1991	Бүрэн дунд
Отгонтэнгэр ИС	Улаанбаатар хот	1991	1995	Баклавар
МУИС	Улаанбаатар хот	1995	1997	Магистр
Осака мужийн ИС	Япон улс	1999	2004	Мастэр
Кобэ ИС	Япон улс	2004	2008	Доктрантур

III. АЖИЛ ЭРХЛЭЛТ /Одоо хийж буй ажлаас эхлэн бичнэ/

Албан байгууллагын нэр	Албан тушаал	Ажилласан хугацаа
Азума шиппинг Монголиа	Захирал	2015 оноос хойш
Азума шиппинг Монголиа	ТУЗ-ийн гишүүн	2011-2015
Төрийн өмчийн хорооны Төрийн өмчийн бүртгэл, хяналт, мониторингийн хэлтэс, Төрийн өмчийн хувьчлал менежментийн хэлтэс	Хэлтэсийн дарга, мэргэжилтэн	2008-2012
Компанийн Засаглалын Институт ТББ	Удирдах Зөвлөлийн гишүүн, Гүйцэтгэх захирал	2008-аас өнөөг хүртэл
МУХАҮТ, Бизнес хөгжил	Мэргэжилтэн	1994-1999
МОТРА,ЖДУ-ийн газар	Мэргэжилтэн	1998
ҮХЯ, Зах зээл судлалын	Судлаач	1995-1997

хүрээлэн		
----------	--	--

2. ДАРААХ ЗҮЙЛИЙГ БАТАЛСАН ТУХАЙ ШИЙДВЭР:

ГУРАВДУГААР АСУУДАЛ. Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нөхөн сонгуульд нэр дэвшүүлэх, сонгох тухай.

1. Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 77 дугаар зүйлийн 77.1 дэх заалтыг тус тус үндэслэн “Монгол Шуудан” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр Ч.Чинзоригийг томилсугай.
2. Томилогдсон гишүүн нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний үүргээ хууль болон компанийн дүрэмд нийцүүлэн компанийн эрх ашгийг дээдлэх зарчмыг баримтлан аливаа сонирхлын зөрчлөөс ангид байж, компанийн нууцыг чанд хадгалж шударгаар ажиллахыг үүрэг болгосугай.

3.ЭНЭ АСУУДЛААР САНАЛ ХУРААСАН ДҮН

С.Анар				Ч.Чинзориг				Түдгэлзэн			
Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/		Нийт саналын эрхтэй хувьцаа /99,586,363 ширхэг/		Хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа /96,327,508 ширхэг/	
Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
99,586,363	100 %	15,821	0.02 %	99,586,363	100 %	96,307,563	99.98 %	99,586,363	100 %	0	0%

Тооллогын комисс нь хуралд оролцсон саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн дараахь саналын хуудсыг хүчингүйд тооцов. Үүнд:

1. Нэгдүгээр асуудлаар нийт 3 хувьцаа эзэмшигчийн 6,277 хувьцааны санал,
2. Хоёрдугаар асуудлаар нийт 0 хувьцаа эзэмшигчийн 0 хувьцааны санал,
3. Гуравдугаар асуудлаар нийт 3 хувьцаа эзэмшигчийн 1,124 хувьцааны санал.

4 дэхь хэлэлцэх асуудал:

1. **ХЭЛЭЛЦСЭН НЬ:** 2016 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн 2016/12 тоот Төлөөлөн Удирдах Зөвлөлийн “Төрийн мэдлийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах” шийдвэр, тогтоол нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.4-д заасны дагуу “Нэг төрлийн хувьцаанд адил хэмжээний ногдол ашиг хуваарилна” гэж заасныг зөрчиж буй тул мөн уг асуудлаар Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох шийдвэр гаргасан байх тул уг шийдвэр хүчингүй болсон тухай танилцуулав.

Хувьцаа эзэмшигчийн хурал зохион байгуулсан зардал Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын зардал нийт 4,850,000 төгрөгийг Монгол Шуудан ХК хариуцуулахаар тохиролцов.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Монгол Шуудан ХК-ийн үйл ажиллагааг өргөжүүлэн, стратегийн түвшинд шинэчлэл явуулах боломжуудын талаар товч презентацыг танилцуулах боломж олгоно уу. Уг асуудлаар санал хураалт явуулахгүй, зөвхөн мэдээллийн чанартай презентацыг танилцуулах боломж олгоно уу.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Санхүү, хөрөнгө оруулалт хариуцсан захирал А.Идэрбат нь: Монгол Шуудан ХК-ийн одоогийн үйл ажиллагаа явуулж байгаа ...-ны хүргэлт, үйлчилгээнээс гадна тээвэр зууч, e-commerce-н болон бусад банк санхүүгийн үйлчилгээг өргөжүүлэн явуулах боломжуудын талаар танилцуулав.

Хурал 14:00 минутанд өндөрлөв.

Тэмдэглэл хөтөдсөн огноо: 2016 оны 9 дүгээр сарын 09.

Хурлын дарга:  /Ч.Ганхуяг/

Хурлын нарийн бичгийн дарга:  /С.Халиунаа/

